



2012 он 3 сар 17 өдөр

Дугаар 01102

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлыг
зарлан хуралдуулах тухай*

Монгол Улсын Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 59.10, 59.11, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4, 71 дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 сарын 10-ны өдрийн 437 тоот тогтоолоор батлагдсан "Хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ийн өдрийн 377 тоот тогтоолоор батлагдсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам", Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн хурлын эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Үндэсний Хувьчлалын Сан" ХОС-ийн Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид "Хурал" гэх)-ыг 2021 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 14:00 цагт цахим хэлбэрээр хуралдуулсугай.

2. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, Саналын хуудасны агуулга, загварыг хоёрдугаар хавсралтаар, Хурлын нийтэд хүргэх зарын загварыг гуравдугаар хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3. Хуралд оролцох эрхтэй Нэгж эрх эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2021 оны 4 дүгээр сарын 7-ны өдрөөр тогтоосугай.

4. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар, өдөр тутмын хоёроос доошгүй сонин болон "Ард Менежмент ҮЦК" ХХК-ийн цахим хуудас, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2021 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн

дотор нийтэд зарласугай. Давтан зарыг 2020 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулсугай.

5. Нэгж эрх эзэмшигчдийн танилцаж болох хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, саналын хуудас, зэрэг бусад холбоотой баримт бичгийг бэлэн болгож 2021 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн дотор хэвлэмэл болон цахим хэлбэрээр үнэт цаасны компаниудад хүргүүлсүгэй.

6. Санал авах хуудсаар урьдчилж санал өгөх сүүлчийн хугацааг 2021 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 14:00 цагаар тасалбар болгосугай.

7. Хурлын даргаар “Үндэсний Хувьчлалын Сан” ХОС-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ч.Ганхуягийг томилсугай.

8. Дараах нэр бүхий хүмүүсийг хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

Хурал зохион байгуулах комиссын дарга:

“Ард Менежмент ҮЦК” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Хандааг

Хурал байгуулах комиссын гишүүд:

“Ард Менежмент” ХХК-ийн хуулийн зөвлөх Ө.Ашхүү

“Ард Менежмент” ХХК-ийн нягтлан бодогч Х.Цэрэннадмид

“Ард Менежмент” ХХК-ийн сангийн менежер Г.Оргил

“Ард Менежмент” ХХК-ийн санхүүгийн шинжээч Ч.Хандсүрэн

9. Дараах нэр бүхий хүмүүсийг хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

Тооллогын комиссын дарга:

“Сноу Хилл” Консалтанси ХХН ахлах хуульч С.Намжилмаа

Тооллогын комиссын гишүүд:

“Сноу Хилл” Консалтанси ХХН хуульч Д.Номин-Эрдэнэ

“Сноу Хилл” Консалтанси ХХН хуульч Т.Оюун-Эрдэнэ

10. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хурлыг зарлан хуралдуулж, хурлын зар мэдээг хүргэж, энэхүү тогтоолыг бүрэн дүүрэн, түргэн шуурхай гүйцэтгэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авч ажиллахыг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.

11. Нэгж эрх эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэсэн шийдвэр болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал Ч.Хандаад даалгасугай.

ДАРГА



Ч.ГАНХУЯГ